

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 10 дугаар  
сарын 10 -ны өдөр

Дугаар А/192

Улаанбаатар  
хот

Журам батлах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 276 дугаар зүйлийн 276.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэн томилох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга /Ц.Амгаланбаяр/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Билгүүн/-д тус тус даалгасугай.

Ц.НЯМДОРЖ

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИЙГ  
АЛБАН ТУШААЛД ДЭВШҮҮЛЭХ, БУУРУУЛАХ, ӨӨР АЛБАН  
ТУШААЛД ШИЛЖҮҮЛЭН ТОМИЛОХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журмаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба хаагчийг хууль, тогтоомжид заасан үндэслэлээр албан тушаалд дэвшүүлэх бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэн томилохтой холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэн томилох харилцаанд Төрийн албаны тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай болон тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад акт болон энэ журмыг баримтална.

1.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь өөрийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нээлттэй чадахуйн зарчмаар сонгон шалгаруулж, мэдлэг чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх бодлого баримтлана.

**Хоёр. Албан тушаалд дэвшүүлэх**

2.1."Төрийн жинхэнэ алба хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам"-д зааснаар сүүлийн гурван жил дараалан "А" буюу "маш сайн" үнэлэгдсэн, тухайн ажлын байранд тавигдах ерөнхий болон тусгай шаардлага хангаж байгаа сахилгын шийтгэлгүй алба хаагчийг дараах нөхцөлийн дагуу дор дурдсан албан тушаалд дэвшүүлж болно. Үүнд:

2.1.1.ахлагчийн бүрэлдэхүүнд 3-аас доошгүй жил ажилласан, дээд боловсролтой алба хаагчийг офицерийн албан тушаалд;

2.1.2.албан тушаалд томилогдоод 5-аас доошгүй жил, үүнээс офицерын албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан алба хаагчийг ахлахын /ахлах мэргэжилтэн, ахлах төлөөлөгч, ахлах нийгмийн ажилтан гэх мэт/ албан тушаалд;

2.1.3.албан тушаалд томилогдоод 8-аас доошгүй жил, үүнээс ахлах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан алба хаагчийг аймаг, нийслэл дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги, салбар нэгжийн /цаашид "салбар нэгж" гэх/ дэд эсхүл шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын /цаашид "төв байгууллага" гэх/ тасаг, хэлтсийн даргын албан тушаалд;

2.1.4.албан тушаалд томилогдоод 10-аас доошгүй жил, үүнээс салбар нэгжийн дэд эсхүл Төв байгууллагын тасаг, хэлтсийн даргын албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан алба хаагчийг салбар нэгжийн даргын албан тушаалд;

2.1.5.албан тушаалд томилогдоод 15-аас доошгүй жил, үүнээс салбар нэгжийн даргын албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан алба хаагчийг Төв байгууллагын газар болон албаны даргын албан тушаалд;

2.2. Алба хаагчийг Төв байгууллагын газрын дарга болон салбар нэгжийн даргын албан тушаалд томилох эсэхийг Төв байгууллагын даргын зөвлөлийн

хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, шийдвэрийг хууль зүйн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнд танилцуулна.

2.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар дотоод болон гадаадын, мэргэжлийн их дээд сургууль төгссөн ахлагчийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа алба хаагчид энэ журмын 2.1.1 дэх заалт хамаарахгүй.

### **Гурав. Албан тушаалд шилжүүлэн томилох**

3.1.Алба хаагчийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 275 дугаар зүйлийн 275.1 дэх хэсэгт заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэг нэгжээс нөгөө нэгжид ажиллуулахаар шилжүүлэн томилж болно.

3.2.Алба хаагч тухайн нэгж болон албан тушаалд томилогдсоноос хойш 3-аас дээш жил тогтвор суурьшилтай, үр дүнтэй ажилласан бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 275 дугаар зүйлийн 275.1 дэх хэсэгт заасан хүсэлтийг гаргаж болно.

3.3.Шилжин ажиллах тухай алба хаагчийн гаргасан хүсэлтийг салбар нэгжийн даргын саналын хамт шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагад хүргүүлнэ.

3.4.Алба хаагчийг шилжүүлэн ажиллуулах асуудлыг орон тоо, хүний нөөцийн мэдээллийг үндэслэн Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга шийдвэрлэнэ.

3.5.Өөр байгууллагад шилжин ажиллах алба хаагчид архивын лавлагаа болон цалингийн тодорхойлолт, бусад шаардлагатай баримт бичгийг гаргаж өгөх бөгөөд хувийн хэргийг тухайн байгууллагын албан бичгийг үндэслэн шилжүүлнэ. Тусгай албаны гүйцэтгэх ажил эрхэлж байсан алба хаагчийн хувийн хэргийг шилжүүлэхгүй.

3.6.Алба хаагчийг төрийн өөр байгууллагад шилжүүлэх тохиолдолд Төрийн албаны тухай хуульд заасан холбогдох зохицуулалтыг баримтлана.

3.7. Алба хаагчийг шилжүүлэн томилох хүртэл ажил үүргийг нь үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх бөгөөд дур мэдэн ажил хаях, хүлээлцэх, шилжүүлэхийг хориглоно.

### **Дөрөв. Албан тушаал бууруулан томилох**

4.1.Алба хаагч тухайн албан тушаалд ажиллах шаардлага хангахгүй байгаа тухай дүгнэлт нь түүнийг захиргааны санаачилгаар албан тушаал бууруулах үндэслэл болно.

4.2.Энэ журмын 4.1-д заасан дүгнэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай болон Төрийн албаны тухай хуульд заасны дагуу алба хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн эрх бүхий албан тушаалтан, салбар нэгжийн дарга гаргана.

4.3.Алба хаагчийн өөрийнх нь хүсэлтээр албан тушаал бууруулан томилж болно.

4.4. Алба хаагчийг албан тушаал бууруулан томилоход Төрийн албаны тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасныг баримтална.

### **Тав. Шийдвэр танилцуулах, ажил хүлээлцэх**

5.1.Алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэн томилох тухай шийдвэрийг нэн даруй тухайн алба хаагчийн харьяалах салбар, нэгжид хүргүүлнэ.

5.2.Албан тушаалд дэвшсэн, буурсан, шилжсэн алба хаагч эрхэлж байсан ажил үүрэг, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж зэргийг холбогдох албан тушаалтан хүлээлгэн өгөх ба тооцоо хийж, салбар нэгжээс олгосон тойрох хуудсыг зуруулж дууссаны дараа байгууллагын зүгээс холбогдох баримт бичгийг гаргаж өгнө.

### **Зургаа. Хүлээх хариуцлага**

6.1.Алба хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, бууруулах өөр албан тушаалд шилжүүлэн томилоход хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчих, түүнчлэн дээрх үйл ажиллагаатай холбогдох материалыг хуурамчаар бүрдүүлэх, засварлах, хуурамч тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа гаргахыг хориглоно.

6.2.Энэхүү журмыг зөрчсөн алба хаагчид хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--oOo--